



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын  
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/9/НА-СТА-ОНА

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Дархан-Уул аймаг  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:  
Утас: 70378845  
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг  
Утас: 70373089  
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхбаяр  
Утас: 89275858  
Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

### **Товчилсон үгийн жагсаалт**

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар



## ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 97

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар өөрчлөлтгүй санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэл тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 690,131.5 мянган төгрөгийн гадна тоглоомын талбай, Дархан-Уул аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,784,238.8 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, 7 багийн автобусын буудлын засвар, Нийгмийн хариуцлагын хүрээнд Мөнх халдун ХХК хөрөнгө оруулалтаар 16,800.0 мянган төгрөгийн замын хашлагыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус байгууллагын 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 95.8 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 12 сарын 31	2026 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	822,556,014.67	154,605,204.47
1.1.2	Дансны авлага		
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		1,313,490.33
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	751,963,691.78	733,643,647.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		-
1.1.10			
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,574,519,706.45</b>	<b>889,562,341.80</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,328,002,043.36	26,977,223,893.00
1.2.2	Биет бус хөрөнгө	2,646,749,830.88	2,646,749,830.68
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>30,974,751,874.24</b>	<b>29,623,973,723.68</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>32,549,271,580.69</b>	<b>30,513,536,065.48</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	-	15,842,861.90
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) -нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>15,842,861.90</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>-</b>	<b>15,842,861.90</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	39,275,814,113.35	<b>41,905,445,559.70</b>
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(6,726,542,532.66)	<b>(11,407,752,356.12)</b>
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>32,549,271,580.69</b>	<b>30,497,693,203.58</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>32,549,271,580.69</b>	<b>30,513,536,065.48</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 12 сарын 31	2026 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>6,085,807,809.38</b>	<b>5,369,424,283.17</b>
2	Борлуулалтын өртөг		
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>6,085,807,809.38</b>	<b>5,369,424,283.17</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	-	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,253,476,411.67	10,007,726,393.93
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	(295,230,236.41)	(42,907,712.70)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(2,462,898,838.70)</b>	<b>(4,681,209,823.46)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(2,462,898,838.70)</b>	<b>(4,681,209,823.46)</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(2,462,898,838.70)</b>	<b>(4,681,209,823.46)</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
26	Бусад олз (гарз)		
27	<b>Орлогын нийт дүн</b>		-
28	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>			<b>39,275,814,113.35</b>	<b>(6,726,542,532.66)</b>	<b>32,549,271,580.69</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>		-	<b>39,275,814,113.35</b>		<b>39,275,814,113.35</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
9	<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>		-	<b>39,275,814,113.35</b>	<b>(6,726,542,532.66)</b>	<b>32,549,271,580.69</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	<b>Залруулсан үлдэгдэл</b>	-	-			-
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-		(4,681,209,823.46)	(4,681,209,823.46)
13	Бусад дэлгэрэнгүй орлого			-		-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-		2,629,631,446.35		2,629,631,446.35
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	<b>2025 оны 12-р сары 31-ний үлдэгдэл</b>	-	-	<b>41,905,445,559.70</b>	<b>(11,407,752,356.12)</b>	<b>30,497,693,203.58</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2025 оны 12 сарын 31	2026 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,870,636,176.05	5,289,136,143.17
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		-
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого	5,064,090,200.00	4,625,276,600.00
	Бусад мөнгөн орлого	1,806,545,976.05	663,859,543.17
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,051,858,152.53	5,522,875,661.41
	Ажиллагчдад төлсөн	2,274,083,322.00	2,709,267,923.55
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	282,149,476.29	348,354,825.77
	Бараа материал худалдан авахад төлсөн		1,098,350,652.22
	Ашиглалтын зардалд төлсөн	859,671,688.08	1,063,572,909.78
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	547,767,666.00	258,054,228.70
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн		4,767,624.00
	Даатгалын төлбөрт төлсөн	9,205,080.00	8,718,990.00
	Бусад мөнгөн зарлага	2,078,980,920.16	31,788,507.39
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>818,778,023.52</b>	<b>(233,739,518.24)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		434,211,291.96
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		434,211,291.96
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>818,778,023.52</b>	<b>(667,950,810.20)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>3,777,991.15</b>	<b>822,556,014.67</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>822,556,014.67</b>	<b>154,605,204.47</b>

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
Нийт орлого	млг	6,085,807,809.38	5,419,313,400.00	5,369,424,283.17	(49,889,116.83)	99%
Үүнээс: орон нутгийн төсвөөс	млг	5,300,979,442.71	4,628,306,600.00	4,705,564,740.00	77,258,140.00	102%
Өөрийн үйл ажиллагаанаас			791,006,800.00	663,859,543.17	(127,147,256.83)	84%
Хог тээвэрлэлтийн орлого		784,828,366.67				
Нийт зардал	млг	8,548,706,648.08	5,419,313,400.00	10,050,634,106.63	-	185%
Үүнээс:	млг					
а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	млг					
б) Ерөнхий ба удирдлагын зардал	млг	8,548,706,648.08	5,419,313,400.00	10,050,634,106.63		185%
в) Хөрөнгө оруулалт их засвар	млг					
Цэвэр ашиг, алдагдал	млг	(2,462,898,838.70)	-	(4,681,209,823.46)	(2,462,898,838.70)	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ нь Дархан сумын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийх, гудамж талбайн гэрэл гэрэлтүүлгийн эвдрэл гэмтлийг засварлах, ногоон байгууламжийн арчилгааг хариуцах гэсэн чиглэлээр үндсэн үйл ажиллагаа явуулдаг Дархан Уул аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм. Үүнд:

- Дархан хотын ногоон байгууламжийг арчлах хамгаалах
- Хотын гэрэл, гэрэлтүүлгийг сайжуурлах, хамгаалах
- Дархан хотын өнгө үзэмжийг сайжруулан хамгаалах, иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэн ажиллах

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын тухай багц хуулиудын мөрдөж ажилладаг байна.

Тайлант хугацаанд Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Тус байгууллагын дарга зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол дотоод хяналтын нэгж санхүүгийн баримт материал, гүйцэтгэлийн баримт бичгийг хянадаг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/17 тоот тушаалаар холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,035,735.60 мянган төгрөгөөр буюу 6.3 өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	822,556.00	154,605.20	(667,950.80)
Авлага	-	1,313.50	1,313.5
Бараа материал	751,963.70	733,643.60	(18,320.10)
Үндсэн хөрөнгө	28,328,002.10	26,977,223.90	(1,350,778.20)
Биет бус хөрөнгө	2,646,749.80	2,646,749.80	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>32,549,271.60</b>	<b>30,513,536.00</b>	<b>(2,035,735.60)</b>
Өр төлбөр	-	15,842.80	15,842.80
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	32,549,271.60	30,497,693.20	(2,051,578.40)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>32,549,271.60</b>	<b>30,513,536.00</b>	<b>(2,035,735.60)</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 154,605,2 мянган төгрөг болж өмнөх оноос 667,950,8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 6,085,807.8 мянган төгрөгийн орлого олж, 8,253,476.4 мянган төгрөгийг зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл 733,643.6 мянган төгрөг болж 18,320.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 1,098,350.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Өсөх урам ХХК-аас 3,088.8 мянган төгрөгийн материал /сагсны шийд, кольцо/ хандиваар, Ургамлын Далай ХХК-аас 67,829.3 мянган төгрөгийн барилгын засварын материал, Захирагчийн ажлын албанаас шарилжгүй дархан дэд хөтөлбөрийн хүрээнд 6,800.0 мянган төгрөгийн цахилгаан хадуур, ир, Дархан сумын хөрөнгө оруулалтаар 2,570.0 мянган төгрөгийн Мөнхнайрамдал талбайн камержуулалт зэргийг тус тус хүлээн авч, үйл ажиллагаандаа 1,196,958.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь зэргээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 26,977,223.9 мянган төгрөг болж 1,350,778.2 мянган төгрөгөөр буурсан нь 434,211,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 болон 21, тогтоолоор 1,100,265,7 мянган төгрөгийн автобус, автобусны буудал, явган зам ногоон байгууламж, Дархан-Уул аймгийн засаг даргын А/80

болон А/398, А/04 тоот захирамжаар 2,211,726,9 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн талбайн тоглоомын тохижилт, явган зам болон тохижилтын хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Дархан-уул аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын 2025 А/40 тоот тушаалаар 395,419,0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлж 112,787,2 мянган төгрөгөөр бүргэсэн, А/41 болон А/35 тоот тушаалаар 855,348,8 мянган төгрөгийг дансны нэр ангилал шилжүүлсэн, Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 23 дугаар тогтоолоор 24,529,2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, Дархан-Уул аймгийн засаг даргын 01-А/397 тоот захирамжаар 97,591,5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, тайлант онд 4,450,899,7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Эздийн өмчийн дүн 30,497,693,2 мянган төгрөг болж 2,051,578.3 мянган төгрөгөөр буурахад дахин үнэлгээний зөрүү, тайлант үеийн 4,681,209,8 мянган төгрөгийн алдагдал, үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө голлон нөлөөлжээ.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-т заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант оны гүйцэтгэлээр 5,369,424.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 10,007,726,3 мянган төгрөгийн зардал гарган, 4,681,209,8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогыг 5,419,313,4 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 5,289,136,1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 130,177,3 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Тайлант онд 4,681,209,8 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь тухайн тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тайлант үеийн ашиг алдагдалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын менежер Н.Уранбайгаль, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны

чанарын хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 67 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 9,038,304.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 90,383.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

“Дархан хотын тохижилт үйлчилгээний газар” ОНӨААТҮГ-ын 2025 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 155 мэдээлэл оруулж 2 мэдээлэл хуулийн хугацаа болоогүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус газрын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд өмчийн дүнг 385,990.5 мянган төгрөг, бараа материал худалдан авахад төлсөн дүнг 59,489,8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан алдаа, зөрчил гарсныг залруулсан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 10,260,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 320,0 мянган төгрөгийн акт, 9,940,0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	360,0	1	360,0	100.0
Зөвлөмж	1	9,940.0	1	9,940.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>10,260.0</b>	<b>2</b>	<b>10,260.0</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 828,899.0 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> нь Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 18.1, НББОУС-1 “Санхүүгийн тайлангийн тодруулга”, НББОУС-7 “Мөнгөн гүйлгээний тайлан”, СТОУС 7 “Санхүүгийн хэрэглүүр, тодруулга”-т заасантай тус тус нийцээгүй тулд аудитын явцад дараах байдлаар залруулав. Үүнд:

- Тус тохижилт үйлчилгээний газрын 2025 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийн дүнг 326,500.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг нэмж бүртгэн залруулсан.
- Тус тохижилт үйлчилгээний газрын 2025 оны хагас жилийн мөнгөн гүйлгээний тайланд бараа материал худалдан авахад төлсөн 59,489.8 мянган төгрөгөөр бусад мөнгөн зарлагаар тайлагнасан байсныг бараа материал худалдан авахад төлсөн мөнгөн зарлагаар бүртгэж залруулсан.
- Татварын цахим тайлангийн системд цалин болон түүнтэй адилтгах орлогыг тайланд оны Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас 8,697.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байсныг нэмж залруулав.
- Тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн 434,211.3 мянган төгрөгөөр үйл ажиллагааны мөнгөн зарлагаар тайлагнасан байсныг хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлагаар бүртгэж залруулсан.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Тус тохижилт үйлчилгээний газрын 2025 оны хагас жилийн санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийн дүнг 326,500.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	326,500.7			1	326,500.7							
Тус тохижилт үйлчилгээний газрын 2025 оны хагас жилийн мөнгөн гүйлгээний тайланд бараа материал худалдан авахад төлсөн мөнгийг 59,489.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	59,489.8			1	59,489.8							
Цалин хөлс болон нэмэгдэл урамшилын зардлын дүн нь цахим татварын тайлангийн ХХОАТ-тай 8,697.2 мянган	1	8,697.2			1	8,697.2							

